

УЛСЫН ХЭМЖЭЭНД 2017 ОНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ ТАНИЛЦУУЛГА


2018.01.09

Улаанбаатар хот

Нэг.ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017 онд 192618 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасны 35212 буюу 18.3 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан байна.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 43910-г хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын тоо нь өнгөрсөн оны үзүүлэлтээс улсын хэмжээнд 7.8 хувиар, Улаанбаатар хотод 8.1 хувиар тус тус буурчээ.



Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага ирүүлсэн сараар харуулсан байдал:



Дээрх судалгаанаас үзэхэд зуны буюу 6,7 дугаар саруудад зам тээврийн ослын шинжтэй дуудлага харьцангуй буурч, амралт зугаалгын улиралд болон их дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг орох, өвлийн хальтиргаа гулгаатай үеүдэд дуудлага мэдээлэл ихэсч байгаа нь харагдаж байна.


Улсын хэмжээнд 36591 зам тээврийн осол бүртгэгдсэний 3929 буюу 10.7 хувь нь орон нутгийн замд, 32662 буюу 89,3 хувь нь Улаанбаатар хотын замд гарсан байна.



Нийслэлд болон орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн ослыг аймаг, дүүргээр нь ангилж үзвэл:



Нийслэлд бүртгэгдсэн 32662 зам тээврийн ослын 3031 буюу 9.3 хувь нь хүний амь нас, эрүүл мэнд тодорхой хэмжээгээр хохирсон осол байхад 26931 буюу 90.7 хувь нь эд материалын хохиролтой осол байна.



Зам тээврийн ослын тоон үзүүлэлтүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзвэл:

1. Гэмт хүүхдийн тоо 8,5 хувиар
2. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 4,8 хувиар
3. Бүртгэгдсэн зам тээврийн осол 21,7 хувиар
4. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага мэдээлэл 2,6 хувиар,
5. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 16,7 хувиар тус тус буурсан бол


1. Гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон хүүхдийн тоо 18 хувиар,
2. Зам тээврийн ослын улмаас амь нас нь хохирсон хүний тоо 5,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хоёр. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2017 онд нийт 33726 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1698 буюу 5.0 хувийг эзэлж байна.



Улсын хэмжээнд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1698 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 4,8 хувиар, нийслэлд 15,9 хувийн бууралттай боловч орон нутагт 6,8 хувиар өссөн байна.



Гэмт хэрэг өссөн аймаг:

- Сүхбаатар 70.8%
- Говьсүмбэр 61.5%
- Орхон 61.5% зэрэг


Гэмт хэрэг өссөн дүүрэг:

- Хан-Уул дүүрэг 6.7%
- Багахангай дүүрэг 33.3%


Улсын хэмжээнд Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт 1698 бүртгэгдсэний 991 нь бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцох зохих этгээд нь тогтоогдоогүй байснаас 558 хэргийг холбогдогчийг олж тогтоон хуулийн дагуу хариуцлага тооцсон бол үлдсэн хэрэг нь шалгалтын ажиллагаанд явагдаж байна.

Гурав. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 507 хүний амь нас хохирч, 1258 хүн гэмтэж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад 9 тэрбум гаруй төгрөгийн хохирол учирсанаас 83.2 хувийг нь нөхөн төлүүлжээ.



Хүний амь нас хохирсон осол улсын хэмжээнд 507 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 5,8 хувиар, орон нутагт 12,2 хувиар тус тус өсч, нийслэлд 11.8 хувиар буурсан үзүүлэлт гарч байна.



Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан 431 хүн, зам тээврийн ослын улмаас гэмтсэн 4712 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:


Улсын хэмжээнд:

- **Явган зорчигч** - 122 нас барж, 2359 гэмтсэн
- **Жолооч** – 133 нас барж, 500 гэмтсэн
- **Тээврийн хэрэгслээр зорчигч** – 166 нас барж, 1769 гэмтсэн
- **Дугуйтай хүн** – 8 нас барж, 84 гэмтсэн


Гэмт хэргийн улмаас гэмтсэн 1258 хүний гэмтлийн зэргээс харахад:

- ❖ Хөнгөн гэмтэл 197 буюу 15.7 %,
- ❖ **Хүндэвтэр гэмтэл** 732 буюу 58.1 %,
- ❖ Хүнд гэмтэл 329 буюу 26.2 % нь байна. Дийлэнх хувь нь зам тээврийн ослын улмаас биедээ хүндэвтэр гэмтэл авч, хөдөлмөрийн чадвараа алдах, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа нь зам тээврийн ослын хор уршгийг харуулж байна.

Гэмт хэрэгт өртөж амь насаа алдсан хүмүүсийн 317 буюу 74.0 хувь нь, гэмтсэн хүний 704 буюу 56.0 хувь нь эрэгтэй хүн эзэлж байна.



Гэмт хэрэгт өртөж хохирсон хүмүүсийн 264 буюу 15.6 хувь нь хүүхэд, 565 буюу 33.5 хувь нь 18-34 насны хүн, 596 буюу 35.3 хувь нь 35-54 насны хүн, 264 буюу 15.6 хувийг 55 ба түүнээс дээш насны хүн эзэлжээ.



Нас, хүйсийн үзүүлэлтээс дүгнэхэд 18-40 насны эрэгтэй хүмүүс нь зам тээврийн осолд өртөж амь насаа алдаж, гэмтсэн нь энэ насны хүмүүс замын хөдөлгөөнд идэвхитэй оролцдогтой холбон үзэж болох юм. Түүнчлэн хөдөлмөрийн насны хүмүүс замын хөдөлгөөнд зөв оролцоогүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн хэн нэгэн буруутай этгээдээс болж амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

Дөрөв. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН


Улсын хэмжээнд бүртгэгдсэн 36591 зам тээврийн ослын 35679 буюу 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 868 буюу 2.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 44 буюу 0.1 хувь нь гарчээ.

№	ШАЛТГААН	УЛС	ЭЗЛЭХ %	ХОТ	ЭЗЛЭХ %	ОРОН НУТАГ	ЭЗЛЭХ %
1	Жолоочийн буруутай үйлдэл	35679	97.5	31868	97.5	3811	97.0
2	Явган зорчигчийн буруутай үйлдэл	868	2.4	768	2.4	100	2.5
3	Замын нөхцөл	44	0.1	26	0.1	18	0.5

❖ Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 15869 буюу 43.4 хувийг хажуу хоорондын зай тохируулаагүйгээс бүртгэгдсэн осол эзэлж байна.



❖ Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын хувьд улсын хэмжээнд 868 буюу нийт бүртгэгдсэн ослын 2.4 хувийг эзэлсэн байна.




Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 868 бүртгэгдсэний 768 буюу 88.5 хувь нь нийслэлд бүртгэгдсэн осол байна. Явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо явган зорчигч замын хөдөлгөөнд согтуугаар оролцож өртсөн тохиолдол 32.7 хувийг эзэлсэн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулсанаас бүртгэгдсэн осол улсын хэмжээнд 63, нийслэлд 42, орон нутагт 21 бүртгэгдсэн байна.

Тав. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 32214 буюу 88.0 хувь нь мөргөлдөх, 2523 буюу 6.9 хувь нь явган зорчигч мөргөх, 850 буюу 2.3 хувь нь онхолдох, 670 буюу 1.8 хувь үл хөдлөх зүйл мөргөх, /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 34 осол зорчигч унагах, 85 унадаг дугуйтай хүн мөргөх, 155 осол мал, амьтан дайрах, 60 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭЭР



Зам тээврийн осол гарсан хэлбэрээс авч үзвэл: Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр гарсан ослын 2189 буюу 86.8 хувь нь НИЙСЛЭЛД, улсын хэмжээнд онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн ослын 717 буюу 84.4 хувь нь ОРОН НУТАГТ бүртгэгджээ.


Зам тээврийн осол гарч буй хэлбэрийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад:

- онхолдох хэлбэрээр гарсан осол 3.4 хувиар,
- үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр гарсан осол 13.1 хувиар,
- зорчигч унагасан хэлбэрээр гарсан осол 35.8 хувиар,
- явган зорчигч мөргөх хэлбэр 7.2 хувиар,
- дугуйтай хүн дайрах хэлбэрээр гарсан осол 37.0 хувиар
- мал амьтан дайрах хэлбэр 20.5 хувиар **бүүрсан** байна.

Зургаа. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ГАРИГ, ЦАГ ХУГАЦАА

Осол гарсан цагийн бүртгэлээс харвал:


- 06.00-12,00 цагийн хооронд 7042 буюу 19.3 хувь,
- 12.00-18.00 цагийн хооронд 11832 буюу 32.3 хувь,
- 18.00-22.00 цагийн хооронд 11132 буюу 30.4 хувь,
- 22.00-06.00 цагийн хооронд 6585 буюу 18.0 хувь нь тус тус бүртгэгджээ.




Зам тээврийн осол их бүртгэгдсэн гариг, цагийн байдлаас авч үзвэл: Ажлын өдрүүдэд буюу Даваа, Баасан гаригуудад нийт ослын 30.7 хувь нь гарч, ажлын цагаар буюу 12.00-18.00 цагуудад нийт ослын 32.3 хувь нь бүртгэгджээ.

Долоо. ХҮҮХЭД ӨРТСӨН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ


2017 оны байдлаар улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1018 бүртгэгдэж, ослын улмаас 59 хүүхэд амь насаа алдаж, 1117 хүүхэд гэмтэл авснаас 205 хүүхэд хүндэвтэр, хүнд гэмтжээ. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад хүүхэд өртсөн ослын гаралт 6.3 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 0.7 хувиар буурч, нас барсан хүүхэд 18.0 хувиар өсчээ.



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 49 буюу 83,1 хувийг орон нутгийн замд гарсан осол эзэлж байна. Өөрөөр хэлбэл орон нутагт зам тээврийн ослын улмаас 49 хүүхэд амь насаа алдсан байна.



Улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоон үзүүлэлтээс харахад: 776 нь явган зорчигч, 292 нь тээврийн хэрэгслээр зорчигч, 49 нь дугуйгаар зорчиж байх үедээ амь насаа алдаж, гэмтэл бэртэл авчээ.



Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн “Гэр-сургууль-цэцэрлэг” гэсэн маршрутаар замын хөдөлгөөнд оролцохдоо зам хөндлөн гарахдаа зорчих хэсгийн гарцтай гарамтай хэсгээр зам хөндлөн гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр зам тээврийн осолд ихээхэн өртөж хохирч байна. Орон нутгийн замд хүүхдийн хамгаалалтын бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвшээгүй, хэрэглэхгүй байгаагаас тээврийн хэрэгслээр зорчигч хүүхдүүд амь насаа алдсаар байна.

Найм. СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ

2017 онд улсын хэмжээнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс 793 зам тээврийн осол бүртгэгдэж, түүний улмаас 96 хүн амь насаа алдаж, 155 хүн гэмтэл бэртэл авчээ. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн осол 3.8 хувиар буурч, согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол 11.6 хувиар өсчээ.

Улсын хэмжээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас 793 зам тээврийн осол бүртгэгдсэн нь нийт ослын 2.2 хувийг эзэлж байна. Тухайн шалтгааны улмаас бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 3.8 хувиар буурсан.

2017 онд улсын хэмжээнд гудамж замын хяналт шалгалтаар согтууруулах ундааны зүйл хэрэглэн замын хөдөлгөөнд оролцсон 17083 зөрчил илрүүлж учирч болох хор уршгаас урьдчилан сэргийлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс илрүүлэлт 27.3 хувиар буурчээ.

ДҮГНЭЛТ

2017 оны байдлаар Монгол улсын замын хөдөлгөөний нөхцөл байдлын тоон үзүүлэлтээс харахад улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага мэдээлэл буурсантай холбоотой бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт улс болон нийслэлийн хэмжээнд буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4.8 хувиар буурсан хэдий ч гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 8.0 хувийн өсөлттэй гарсан. Нас барсан хүний дийлэнх буюу 79.6 хувь нь орон нутгийн замд үйлдэгдсэн ослын улмаас амь насаа алдсан байна. Орон нутгийн замд гарсан ослын хэлбэрээс авч үзэхэд онхолдох хэлбэрээр олон хүний амь нас хохирох, гэмтэх тохиолдол их байна гэж үзэж болно. Түүнчлэн хүүхэд өртсөн зам тээврийн осол улсын хэмжээнд 6.3 хувиар буурсан боловч нас баралт 18.0 хувиар өссөн нь онц ноцтой, хохирол ихтэй буюу хүндэвтэр гэмт хэргийн гаралт ихэссэнтэй холбон үзэж байна.

Монгол улсад 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцлөөс харахад жолоочийн буруутай үйлдлээс 97.5 хувь нь бүртгэгдсэн байна. Жолоочийн буруутай үйлдэл дотроо хажуу хоорондын зай тохируулаагүй, эгнээ байр, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэснээс гарсан осол давамгайлж байна. Хурд хэтрүүлсэн болон согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан зам тээврийн осол буурсан үзүүлэлттэй ч орон нутагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, хурд хэтрүүлсэнээс гарсан осол нилээдгүй хувийг эзэлж байна.

ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБА